



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/850

Ховд

“Ахуйн үйлчилгээний өдөрлөг
зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай”


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 “а”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр 1.3.7.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ахуйн үйлчилгээний ажиллагсдын мэргэжил, ур чадвар, үйлчилгээний чанар, соёл, хүртээмжийг сайжруулах зорилгоор зохион байгуулж буй “Явуулын ахуйн үйлчилгээ”-ний зардлын төсвийг хавсралтаар баталсугай.

2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 2353500 төгрөг /Хоёр сая гурван зуун тавин гурван мянга таван зуун/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн 2019 оны батлагдсан төсвийн 5.34 дэх “Ховдын брэнд бүтээгдэхүүний” арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.


3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
12 дугаар сарын 18-ны өдрийн
А/850 дугаар захирамжийн хавсралт



“ЯВУУЛЫН АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨДӨРЛӨГ”
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ЗАДАРГАА

д/д	Зардлын нэрс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Хөрөнгийн эх үүсвэр
1	Өргөмжлөл	ш	18	20000	360000	АЗДТГазар
2	1-р байр мөнгөн шагнал	ш	6	50000	300000	
3	2-р байр мөнгөн шагнал	ш	6	30000	180000	
4	3-р байр мөнгөн шагнал	ш	6	20000	120000	
5	Шатахуун	ш	150	2090	313500	
6	Анонс	ш	1	120000	120000	
7	Мандат	ш	300	600	18000	
8	Бусад /хоол, байр/	ш	6		780000	
Нийт					2353500	

-oOo-